



**“АЛАГ УУЛ ФИНАНС АУДИТ”
ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот, СБД,
1-р хороо, Нарны зам-62, Юнион бюлдинг
оффис, А блок, 16 давхар 1605 тоот
Утас: 9911 5486, 7000 5486
И-мэйл: alaguulaudit@gmail.com

**“ХОРИН ХОЁР ДУГААР БААЗ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД**

2021.03.31 № 21120
-ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх дүгнэлт

Бид “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, бусад тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангуудад 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг МУ-ын НББ-ийн тухай хуулийн дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.

Бид Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу компаниас хараат бус байсан бөгөөд бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нөхцөл байдалдаа тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх, санхүүгийн тайлангуудыг аливаа заль мэх эсвэл алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэх, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөн ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлүүдийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэгдэнэ. Аудитад мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

ЗАХИРАЛ  Д.ОТГОНЖАРГАЛ